



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/Н5

Улаанбаатар хот

□ Бараа хүлээн авах комисс томилох тухай □

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төв болон орон нутгийн аэродромын засвар арчлалтад шаардлагатай мастик" нийлүүлэх ИНЕГ/УЗ/69/2022 дугаартай гэрээний дагуу бараа хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Д.Цогням

(Нисэх буудлуудын үйлчилгээний газрын
үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан менежер)

Гишүүд:

Ц.Шижир-Эрдэнэ

("Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын,
Аэродромын хэсгийн ашиглалтын ахлах инженер)

М.Содномдорж

("Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын,
Аэродромын хэсгийн ашиглалтын ахлах техникч)

С.Эрдэнэчимэг

("Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын, Санхүү
төлөвлөлтийн хэлтсийн нярав)

Н.Отгонжаргал

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Төлөвлөлт
гүйцэтгэлийн тасгийн инженер)

2.Гэрээний хүрээнд нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг техникийн тодорхойлолт, гэрээнд заасан тоо хэмжээ, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, бусад баримт бичгийг бүрдүүлж, 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор Иргэний нисэхийн үндэсний төвийн, Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд хүргүүлэхийг комисс (Д.Цогням)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА